

## **Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажлын явцаа**

### **Монгол Улс дүгнүүлэв**

Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий Ази номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн Жилийн уулзалт, Техникийн туслалцааны форум 2007 оны 7 дугаар сарын 23-ны өдрөөс 27-ны өдрийн хооронд Австралийн Пэрт хотод амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Жилийн уулзалтаар дээрх бүлэг нь өөрийн зарим гишүүн орнуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй хэрхэн тэмцэж байгаа байдлын талаарх тайлангуудыг хэлэлцэн үнэлэлт дүгнэлт өгч дүнг бүс нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр мэдээлдэг уламжлалтай. Манай улс энэ бүлэгт 2004 онд элсэн орсноос хойш өөрийн улсын мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог анх удаагаа дүгнүүлэв.

Монгол улсыг төлөөлж энэхүү уулзалтад Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, Гадаад хэргийн яамны холбогдох албан тушаалтнуудаас бүрдсэн баг төлөөлөгчид оролцож Монгол улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаар ямар ажлууд хийгдэж байгаа талаар дэлгэрэнгүй тайланг тавиж үр дүнг амжилттай хамгаалаад ирсэн байна.